ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**Алтай сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

**Аудитын код:** ГАА-2022/32/-НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Алтай хот<br>2022 он | Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр<br>Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn<br>Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг<br>Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Ж.Бүжинханд<br>Утас: 99177546 Цахим хаяг: Bujinkhandj@audit.gov.mn<br>Аудитор Г.Энхдэлгэр<br>Утас: 70484030 Цахим хаяг: Enkhdelgerg@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга


1. Аудитын санал дүгнэлт ....... **Error! Bookmark not defined.**
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ....... 2
3. Аудитын тайлан ....... 7
   - 3.1 Ерөнхий зүйл ....... 7
   - 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ....... 8
   - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ....... 8
   - 3.4 Материаллаг байдал ....... 8
   - 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ....... 9
   - 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ....... 9
   - 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ....... 10
   - 3.8 Аудитын гол асуудал ....... 10
   - 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....... 10
   - 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ....... 11
   - 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ....... 11
4. Аудитын илрүүлэлт ....... 11
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ....... 12


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |



Говь-Алтай а... ТӨРИЙН АУ... ГАЗАР

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E –mail: govialtai@audit.gov.mn

2022. 02. 25 № 107

танай ______ -ны № ______ -т

АЛТАЙ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА Ц.АНХЗАЯА ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Алтай сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Алтай сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Татварын тодорхойлолтоор зөрүү тооцоо татварын цахим системд бүртгэлтэй, Эмийн эргэлтийн сан хариуцаж байсан ажилтнаас авах эмийн авлагыг барагдуулаагүй, нийгмийн даатгалын тайланд цалин дутуу тайлагнасан, тайлант хугацаанд эм акталж утсгасан зэрэг 21.6 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалт, АДБОУС 1250, 1300, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4 заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

07020341

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Х.ТҮВШИНБАЯР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I) | 79,289,107.66 | 272,342,680.03 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | - | 4,370,297.43 |
| 31200 | Банкинд байгаа бэлэн мөнгө | - | 4,370,297.43 |
| 31210 | Төгрөг | - | 4,370,297.43 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | - | 4,279,552.43 |
| 31215 | Нэмэлт санхүүжилтийн харилцах (НД) | - | 90,745.00 |
| 33 | АВЛАГА | 10,253,684.00 | 157,030,426.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 400,000.00 | - |
| 33101 | Цалингийн авлага | 400,000.00 | - |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | - | 147,277,500.00 |
| 33500 | Бусад авлага | 9,853,684.00 | 9,330,805.00 |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 522,879.00 | - |
| 33520 | Хувь хүмүүсээс авах авлага | 9,330,805.00 | 9,330,805.00 |
| 33402 | Татвар НДШ-н авлага (ТӨҮГ) | - | 422,121.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 69,035,423.66 | 110,941,956.60 |
| 35100 | Түүхий эд материал | 18,656,993.66 | 48,430,354.89 |
| 35130 | Эм боох материал | 18,656,993.66 | 48,430,354.89 |
| 35400 | Хангамжийн материал | 50,378,430.00 | 62,511,601.70 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 166,400.00 | 1,479,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 25,379,680.00 | 24,291,050.00 |
| 35460 | Хүнсний материал | 1,067,130.00 | 4,743,340.00 |
| 35600 | Мал амьтад | 1,600,000.00 | - |
| 35470 | Бусад хангамжийн материал | 22,165,220.00 | 31,998,211.70 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II) | 476,973,219.62 | 671,859,436.32 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 476,973,219.62 | 671,859,436.32 |
| 39200 | Биет хөрөнгө | 467,449,219.62 | 662,335,436.32 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 320,429,612.08 | 570,429,612.08 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл - Барилга | (23,993,065.94) | (34,969,094.17) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 73,560,000.01 | 45,264,613.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл - Тээврийн хэрэгсэл | (52,417,222.31) | (25,832,606.72) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 359,727,130.00 | 380,515,470.65 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж | (233,873,808.57) | (297,523,625.64) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 44,442,090.00 | 50,327,409.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл - Тавилга | (20,487,515.65) | (25,938,341.88) |
| 39217 | Номын фонд | 62,000.00 | 62,000.00 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 9,524,000.00 | 9,524,000.00 |
| 39301 | Програм хангамж | 550,000.00 | - |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл - Програм хангамж | (550,000.00) | - |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 9,524,000.00 | 9,524,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II) | 556,262,327.28 | 944,202,116.34 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV) | - | 50,000.00 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | - | 50,000.00 |
| 41300 | Өглөг | - | 50,000.00 |
| 41360 | Бусад өглөг | - | 50,000.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | 50,000.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V) | 556,262,327.28 | 944,152,116.34 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 556,262,327.28 | 944,152,116.34 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 348,310,192.08 | 348,310,192.08 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 47,020,539.74 | 434,910,328.80 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 89,965,757.56 | 47,020,539.74 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (42,945,217.82) | 387,889,789.06 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 160,931,595.46 | 160,931,595.46 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V) | 556,262,327.28 | 944,202,116.34 |



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Код | Үзүүлэлт | Өмнөх жилийн дүн | Тайлант жилийн дүн |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 423,331,268.80 | 1,168,523,027.29 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 41,928,168.80 | 451,208,768.29 |
| 1200 | Нийтлэг татварын бус орлого | 41,928,168.80 | 451,208,768.29 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 23,670,499.00 | - |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 23,670,499.00 | - |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | - | 288,821,062.65 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 18,257,669.80 | 162,387,705.64 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 381,403,100.00 | 717,314,259.00 |
| 1310 | Улсын төсвөөс | 338,572,400.00 | 397,890,500.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 338,572,400.00 | 397,890,500.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 8,785,900.00 | 291,975,239.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 239,400.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х | 8,318,500.00 | 26,789,169.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 228,000.00 | 12,151,070.00 |
| 131107 | Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого | - | 253,035,000.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 26,042,800.00 | 22,096,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 26,042,800.00 | 22,096,000.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 8,002,000.00 | 5,352,520.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 8,002,000.00 | 5,352,520.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II) | 466,276,486.62 | 780,517,523.94 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 466,276,486.62 | 780,517,523.94 |
| 210 | БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 463,755,903.62 | 754,291,823.94 |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 234,645,381.00 | 304,376,382.00 |
| 210101 | Үндсэн цалин | 173,678,073.00 | 209,102,093.00 |
| 210102 | Нэмэгдэл | 41,979,168.00 | 54,525,015.00 |
| 210103 | Унаа хоолны Хөнгөлөлт | 4,085,000.00 | 4,861,561.00 |
| 210104 | Урамшуулал | 14,903,140.00 | 21,229,600.00 |
| 210105 | Гэрээт ажлын цалин | - | 14,658,113.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 29,838,243.00 | 40,262,821.57 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 20,455,409.00 | 29,205,436.45 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,103,400.00 | 2,687,916.78 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,982,400.00 | 2,331,096.63 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 485,703.00 | 533,807.15 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,811,331.00 | 5,504,564.56 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 14,839,682.00 | 18,248,750.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,473,682.00 | 2,226,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 13,166,000.00 | 15,742,750.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 200,000.00 | 280,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 35,145,617.00 | 63,073,123.99 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,075,100.00 | 649,450.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 27,165,760.00 | 34,752,792.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 705,230.00 | 1,081,900.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 150,000.00 | 150,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 926,860.00 | 4,266,110.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 773,160.00 | 7,685,220.00 |
| 210408 | Бараа материал актласны зардал | 4,349,507.00 | 14,487,651.99 |
| 2105 | Нормативт зардал | 31,032,220.06 | 207,577,076.72 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 22,294,595.06 | 190,342,286.72 |
| 210502 | Хоол, хүнс | 8,737,625.00 | 17,234,790.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 3,383,600.00 | 4,488,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,383,600.00 | 4,488,500.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,979,400.00 | 1,797,700.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,979,400.00 | 1,797,700.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 19,910,088.00 | 2,516,726.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 18,435,500.00 | 1,028,826.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 480,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 203,400.00 | 350,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 45,188.00 | 65,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 22,000.00 | 22,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 13,000.00 | 13,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 711,000.00 | 1,037,900.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 92,981,672.56 | 111,950,743.66 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,412,100.00 | 2,438,700.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол | 88,569,572.56 | 109,512,043.66 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 2,520,583.00 | 26,225,700.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 446,318.00 | 37,700.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 446,318.00 | 37,700.00 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 1,374,265.00 | - |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,374,265.00 | - |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 700,000.00 | 26,188,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 700,000.00 | 26,188,000.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | - | 115,714.29 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II) | (42,945,217.82) | 388,005,503.35 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV) | - | - |
| 5 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V) | - | 115,714.29 |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ | - | 115,714.29 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | - | 115,714.29 |
| 6 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V) | (42,945,217.82) | 387,889,789.06 |



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын хөрөнгө оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | НИЙТ ДҮН |
|---|---|---|---|---|---|
| 1 | ҮЛДЭГДЭЛ | - | - | - | - |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| 7 | Тайлант үеийн үр дүн | - | - | - | - |
| 8 | ҮЛДЭГДЭЛ | 348,310,192.08 | 160,931,595.46 | 47,020,539.74 | 556,262,327.28 |
| 9 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| 10 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 348,310,192.08 | 160,931,595.46 | 47,020,539.74 | 556,262,327.28 |
| 11 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | - | - | - | - |
| 12 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | - | - | - | - |
| 13 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз | - | - | - | - |
| 14 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - |
| 15 | Тайлант үеийн үр дүн | - | - | 387,889,789.06 | 387,889,789.06 |
| 16 | ҮЛДЭГДЭЛ | 348,310,192.08 | 160,931,595.46 | 434,910,328.81 | 944,152,116.34 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Код | Үзүүлэлт | Өмнөх жилийн дүн | Тайлант жилийн дүн |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 381,403,100.00 | 570,061,005.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 381,403,100.00 | 570,061,005.00 |
| 1310 | Улсын төсвөөс | 338,572,400.00 | 397,890,500.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 338,572,400.00 | 397,890,500.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 8,785,900.00 | 144,721,985.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 239,400.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х | 8,318,500.00 | 26,789,169.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 228,000.00 | 12,175,316.00 |
| 131107 | Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого | - | 105,757,500.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 26,042,800.00 | 22,096,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 26,042,800.00 | 22,096,000.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 8,002,000.00 | 5,352,520.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 8,002,000.00 | 5,352,520.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II) | 372,705,100.00 | 549,997,795.57 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 372,705,100.00 | 549,997,795.57 |
| 210 | БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 370,184,517.00 | 523,772,095.57 |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 235,519,014.00 | 303,063,156.00 |
| 210101 | Үндсэн цалин | 174,551,706.00 | 209,323,710.00 |
| 210102 | Нэмэгдэл | 41,979,168.00 | 52,990,172.00 |
| 210103 | Унаа хоолны Хөнгөлөлт | 4,085,000.00 | 4,861,561.00 |
| 210104 | Урамшуулал | 14,903,140.00 | 21,229,600.00 |
| 210105 | Гэрээт ажлын цалин | - | 14,658,113.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 29,838,243.00 | 41,121,535.57 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 20,455,409.00 | 30,064,150.45 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,103,400.00 | 2,687,916.78 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,982,400.00 | 2,331,096.63 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 485,703.00 | 533,807.15 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,811,331.00 | 5,504,564.56 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 21,287,682.00 | 18,685,800.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,473,682.00 | 2,226,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 19,614,000.00 | 16,179,800.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 200,000.00 | 280,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 31,808,490.00 | 40,628,962.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,000,000.00 | 1,799,950.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 27,165,760.00 | 31,939,912.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,242,730.00 | 1,081,900.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 150,000.00 | 150,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 600,000.00 | 2,460,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 650,000.00 | 3,197,200.00 |
| 2105 | Нормативт зардал | 20,991,700.00 | 109,651,859.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 10,891,700.00 | 88,392,859.00 |
| 210502 | Хоол, хүнс | 8,100,000.00 | 19,259,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,000,000.00 | 2,000,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 4,308,800.00 | 3,478,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,308,800.00 | 3,478,500.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,979,400.00 | 2,024,757.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,979,400.00 | 2,024,757.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 19,799,088.00 | 2,678,826.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 18,435,500.00 | 1,028,826.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 480,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 203,400.00 | 350,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 45,188.00 | 65,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 22,000.00 | 22,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 13,000.00 | 13,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 600,000.00 | 1,200,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,652,100.00 | 2,438,700.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,652,100.00 | 2,438,700.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 2,520,583.00 | 26,225,700.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 446,318.00 | 37,700.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 446,318.00 | 37,700.00 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 1,374,265.00 | - |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,374,265.00 | - |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 700,000.00 | 26,188,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 700,000.00 | 26,188,000.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II) | 8,698,000.00 | 20,063,209.43 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 8,698,000.00 | 15,692,912.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 8,698,000.00 | 15,692,912.00 |
| 223 | БУСАД ХӨРӨНГӨ | 8,698,000.00 | 15,692,912.00 |
| 223004 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 8,698,000.00 | 15,692,912.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V) | (8,698,000.00) | (15,692,912.00) |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII) | - | 4,370,297.43 |
| 14 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |
| 15 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 4,370,297.43 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны Батлагдсан төлөвлөгөө | Цэвэр гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **440,730,500.0** | **421,021,767.57** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 440,730,500.0 | 421,021,767.6 |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 439,742,500.0 | 420,033,767.57 |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 277,906,000.0 | 273,162,962.00 |
| 210101 | Үндсэн цалин | 186,966,100.0 | 188,192,170.00 |
| 210102 | Нэмэгдэл | 55,788,100.0 | 52,990,172.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 6,050,000.0 | 4,861,561.00 |
| 210104 | Урамшуулал | 12,500,000.0 | 12,500,000.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 16,601,800.0 | 14,619,059.00 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 39,285,000.0 | 37,268,445.57 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 27,645,000.0 | 26,211,060.45 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,910,000.0 | 2,687,916.78 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,328,000.0 | 2,331,096.63 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 582,000.0 | 533,807.15 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,820,000.0 | 5,504,564.56 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 18,587,000.0 | 18,579,800.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,120,000.0 | 2,120,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 16,187,000.0 | 16,179,800.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 280,000.0 | 280,000.00 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | 36,515,500.0 | 36,005,350.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,500,000.0 | 1,499,950.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 31,183,500.0 | 31,183,500.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,632,000.0 | 1,081,900.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 150,000.0 | 150,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариу | 1,200,000.0 | 1,240,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 850,000.0 | 850,000.00 |
| 2105 | **Норматив зардал** | 45,304,000.0 | 33,241,884.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 37,145,000.0 | 25,082,884.00 |
| 210502 | Хоол, хүнс | 6,159,000.0 | 6,159,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,000,000.0 | 2,000,000.00 |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 15,786,300.0 | 15,755,800.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 9,477,300.0 | 9,477,300.00 |
| 210602 | Тавилга | 2,800,000.0 | 2,800,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,509,000.0 | 3,478,500.00 |
| 2107 | **Томилолт, зочны зардал** | 1,110,000.0 | 902,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,110,000.0 | 902,000.00 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, ху** | 2,770,000.0 | 2,678,826.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,120,000.0 | 1,028,826.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 350,000.0 | 350,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 65,000.0 | 65,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 22,000.0 | 22,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 13,000.0 | 13,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 1,200,000.0 | 1,200,000.00 |
| 2109 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 2,478,700.0 | 2,438,700.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,478,700.0 | 2,438,700.00 |
| 213 | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 988,000.00 | 988,000.00 |
| 2132 | **Бусад урсгал шилжүүлэг** | 988,000.0 | 988,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 988,000.0 | 988,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **440,730,500.0** | **425,301,320.00** |
| 1310 | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 397,890,500.0 | 397,890,500.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 397,890,500.0 | 397,890,500.00 |
| 1320 | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 22,096,000.0 | 22,058,300.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 22,096,000.0 | 22,058,300.00 |
| 1340 | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 20,744,000.0 | 5,352,520.0 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | - | - |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 20,744,000.0 | 5,352,520.00 |
| 4 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| 5 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | **4,279,552.43** |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 1 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | - | **144,631,240.0** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | - | 144,631,240.0 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | - | 119,431,240.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | - | 29,900,194.00 |
| 210101 | Үндсэн цалин | | 21,131,540.00 |
| 210104 | Урамшуулал | | 8,729,600.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | | 39,054.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | - | 3,853,090.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | | 3,853,090.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | - | 106,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | | 106,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | - | 4,623,612.00 |
| 210401 | Бичиг хэрэг | | 300,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 756,412.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | 1,220,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 2,347,200.00 |
| **2105** | **Норматив зардал** | - | 76,409,975.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | | 63,309,975.00 |
| 210502 | Хоол, хүнс | | 13,100,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | 3,415,612.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | 3,415,612.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | - | 1,122,757.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | | 1,122,757.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | - | 25,200,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | 25,200,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 25,200,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | - | **144,721,985.0** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 144,721,985.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 26,789,169.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 12,175,316.00 |
| 131107 | Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого | - | 105,757,500.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | - |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | **90,745.00** |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Алтай сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Энхдэлгэр гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг , дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Алтай сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 21-ний өдрийн 2 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Алтай сумын Эрүүл мэндийн төв нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээ явуулдаг Эрүүл мэндийн яамны харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Алтай сумын Эрүүл мэндийн төв нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн зардлын 465.0 сая төгрөгөөс 2 хувиар буюу 9.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 7.4 сая төгрөгөөр тогтоосон.



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2021 оны үр дүнгийн тайлангийн зардлын 780.5 сая төгрөгөөс 2 хувиар буюу 15.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 12.5 сая төгрөгөөр тогтоосон.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Алтай сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 69.7 хувиар буюу 388.0 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөг, эздийн өмчийн данс байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 110.9 сая төгрөг болж 41.9 сая төгрөгөөр өссөн нь ковид 19 вирусын тархалтын үед хүлээн авсан эм, эмнэлгийн хэрэгсэл, түүний зарцуулалттай холбоотой байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 169.7 сая төгрөгийн бараа материал бэлтгэж, үнэ төлбөргүйгээр 163.9 сая төгрөгийн бараа материал хүлээн авч, үйл ажиллагаандаа 277.2 сая төгрөгийн материалыг зарцуулжээ. Оны эцэст 110.9 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,056.1 сая төгрөг болж 247.8 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 15.7 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, 288.8 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авч, 56.7 сая төгрөгийн хөрөнгийг акталсантай холбоотой байна. Оны эцэст 1,056.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Авлага дансны үлдэгдэлд Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлогоос авах татаас санхүүжилтын 147.3 сая төгрөгийн авлага, НДШ-ийн 0.4 сая төгрөгийн авлага үүссэн.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 944.2 сая төгрөг болж 387.9 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 434.9 сая төгрөг болсон байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 440.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 2 хөтөлбөрийн хүрээнд 4 арга хэмжээг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс санхүүжүүлэхээр 397.9 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 22.1 сая төгрөг, ЭМД-ын сангаас 20.7 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 397.9 сая төгрөгийн санхүүжилт авч, орон нутгийн төсвөөс 22.1 сая төгрөг, ЭМД-ын сангаас 5.4 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 421.0 сая төгрөгийг зарцуулж, орон нутгийн санхүүжилтээс 0.04 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 421.0 сая төгрөг буюу 96 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлыг 4.7 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд

төлөх шимтгэлийг 2.0 сая төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 0.5 сая төгрөгөөр, нормативт зардлыг 12.1 сая төгрөгөөр, томилолт, зочны зардлыг 0.2 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 0.1 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний зардлыг 0.04 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 144.7 сая төгрөгийн санхүүжилт орж, урсгал зардалд 144.6 сая төгрөгийг зарцуулж, 0.1 сая төгрөгийн үлдэгдлээр тайлагнасан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав

## 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

## 3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

## 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт, байгууллагын санхүүгийн тайлан болон татварын цахим систем дэх татварын өглөг, авлагын тооцооллыг хяналаа.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 169 мэдээллээс 166 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн ба хугацаа хоцроосон 3 мэдээлэл байна. Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 123.5 сая төгрөгийн мөнгөн гүйлгээг мэдээлээгүй.

### 3.9.2 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т "Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дор дурдсан тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулна" гэсэн заалттай нийцсэн байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1.0 сая төгрөгийн төлбөрийн акт, 3.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлснийг хэрэгжүүлсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар тээвэр шатахууны зарцуулалт, бараа материалын тайланг үзэх нь зүйтэй. Мөн тайлант онд эм боох материалыг их хэмжээгээр азталж устгасан тул дараагийн аудитаар онцолж үзэх нь зүйтэй.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 27.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 6.0 сая төгрөгийн алдааг залруулж, 21.6 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж хүргүүллээ.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад 6.0 сая төгрөгийн төлбөрийн баримтыг нөхөж шивүүлсэн.

### 4.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй.

### 4.3 Албан шаардлага

Татварын тодорхойлолтоор 1.1 сая төгрөгийн зөрүү тооцоо татварын цахим системд бүртгэлтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-т "Аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.2-т "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 14.4.3-т "Бүх өр төлбөр" заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Тайлант хугацаанд хугацаа дууссан шалтгаанаар 8.6 сая төгрөгийн эм акталж төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалт "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Эмийн эргэлтийн сан хариуцаж байсан ажилтнаас авах эмийн 9.3 сая төгрөг авлагыг барагдуулаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Нийгмийн даатгалын тайланд цалинг 2.5 сая төгрөгөөр дутуу тайлагнасан нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалт "Ажил олгогч болон энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагч нь шимтгэл төлөх талаар дор дурдсан үүрэг хүлээнэ: 1/хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд ногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх;" заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

**4.4 Зөвлөмж**

Аудитаар илэрсэн зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудал***

1.1. Илрүүлэлт: Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 123.5 сая төгрөгийн мөнгөн гүйлгээг мэдээлээгүй.

1.2. Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах.

## 2. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Алтай сумын Эрүүл мэндийн төв | 6 | 27.6 | 1 | 6.0 | | | 4 | 21.6 | 1 | 0 |